



АСУУХ БУЛАН




“Аав, ээж хоёрыгоо маргалдах үед би санаа зовж, гунигладаг. Би юу хийж чадах вэ?”



Та Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч чадна. Энэ нь миний сэтгэлийг үргэлж онгойлгодог.  
**Хэйдэн Х., 6 настай, Канадын Алберта**



Та аав, ээж хоёртоо асуудлаа шийдэхэд нь туслахын тулд залбирч, өөртөө сайхан мэдрэмж төрүүлэхийн тулд Сүмийн дууллыг амандаа аялж болно.  
**Аддисон С., 10 настай, АНУ-ын Вашингтон**



Би тэднийг инээлгэхийн тулд хөгжилтэй түүх болон сургууль дээр ямар байснаа ярьж өгдөг. Тэднийг инээх үед Ариун Сүнс надад зөв зүйл хийсэн гэдгийг хэлж байгааг би мэдэрдэг.  
**Елена М., 12 настай, АНУ-ын Калифорни**



Би ах, эгч, дүү нартайгаа өрөөндөө орж, табернеклын найрал дуут сонсдог. Энэ надад амар амгаланг мэдрэхэд тусалдаг.  
**Бэн М., 11 настай, Австралийн Брисбэн**



Би аав, ээжийгээ маргалдах үед Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, тэдэнд Сүнсийг мэдэрч, асуудлаа шийдэхэд нь туслахыг гуйдаг.  
**Итан М., 11 настай, АНУ-ын Калифорни**



**Макс:** Би тэднийг тэвэрч, тэдэнд Есүсийн тухай сануулахын тулд Хүүхдийн хэсгийн дуу дуулж өгдөг.



**Гэйб:** Гэр бүлээ тэнгэрт байгаагаар зурж, эцэг эхийнхээ сэтгэлийг сайхан болго.  
**Макс, Гэйб С., 6 болон 10 настай, Энэтхэгийн Кочи**

ДАРГАГИЙН АСУУЛТ

“Мацаг барьж эхлэх насанд хүрснээ хэрхэн мэдэх вэ?”

Танд энэ талаар өгөх зөвлөгөө байна уу? Хариулт болон зургаа 2016 оны 10-р сарын 31-ний дотор бидэнд ирүүлнэ үү. Та хариултаа онлайнгаар [liahona.lds.org](http://liahona.lds.org) вэбсайтаар илгээж эсвэл бидэнд [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) хаягаар э-мэйл бичиж болно. (Гарчган дээр “Асуултын булан” гэж бичээрэй.) Эцэг эхийнхээ зөвшөөрлийг хамт явуулахаа битгий мартаарай!